WWF

BOOK

MNG

This project is funded by the European Union

УУЛ УУРХАЙН ШИЙДВЭР ГАРГАЛТАНД ОРОН НУТГИЙН ИРГЭД, ОЛОН НИЙТ ХЭРХЭН ОРОЛЦОХ ВЭ?



УУЛ УУРХАЙН ШИЙДВЭР ГАРГАЛТАНД ОРОН НУТГИЙН ИРГЭД, ОЛОН НИЙТ ХЭРХЭН ОРОЛЦОХ ВЭ?

Улаанбаатар 2017

ДАА 622
ННА 33
У-591

УУЛ УУРХАЙН ШИЙДВЭР ГАРГАЛТАНД ОРОН НУТГИЙН ИРГЭД, ОЛОН НИЙТ ХЭРХЭН ОРОЛЦОХ ВЭ?

Зохиолч: Ногоон хөгжлийн хөтөч ТББ
Хянасан: Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF)-гийн
Монгол дахь хөтөлбөрийн газар

Зураач: Галмандахын Амарсанаа
Хэвлэлийн эхийг: Хорлоогийн Балдандорж

ISBN: 978-99978-1-521-7

ӨМНӨХ ҮГ

Монгол Улсад уул уурхайн салбарын оролцогч талуудад тулгарч буй үндсэн бэрхшээл нь мэдээллийн хомсдол юм. Энэ нөхцөл байдлаас шалтгаалан талуудын хооронд үл ойлголцол үүсдэг тул хамтран ажиллахад хүндрэлтэй байдаг.

Тиймээс Европын холбооны санхүүжилттэйгээр Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF)-гийн Монгол дахь хөтөлбөрийн газраас хэрэгжиж буй “Уул уурхайн хөрөнгө оруулалтын төлөвлөлтөнд талуудын оролцоог нэмэгдүүлэх замаар Монгол орны ард иргэд, мал сүргийн эрүүл амьдрах аюулгүй орчинг бүрдүүлэх ба байгаль орчныг хамгаалах нь” төслийн хүрээнд малчин ард иргэд, орон нутгийн засаг захиргаа, иргэний нийгмийн байгууллага (ИНБ)-ууд, уул уурхайн аж ахуйн нэгжүүдэд зориулсан цуврал сургалтуудыг амжилттай зохион байгууллаа.

Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF)-гийн Монгол дахь хөтөлбөрийн газраас боловсруулан хүргэж буй энэхүү олон нийтэд зориулсан зурагт ном нь сургалтын гарын авлагын хялбаршуулсан эмхэтгэл бөгөөд уул уурхайн нөлөөлөлд буй иргэдийн болон бусад талуудын хамтын ажиллагаа, шийдвэр гаргалтанд оролцоход бодитой мэдлэгийн эх үүсвэр болно гэж итгэж байна.

Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF)-гийн
Монгол дахь хөтөлбөрийн газар

Нутгийн малчин Б.Ирээдүйнх намаржаандаа буугаад удаагүй байтал багийн Засаг дарга Д.Болд утсаар ярьж 7 хоногийн дараа багийн нийтийн хурал болох тухай мэдэгдэв.

Багийн Засаг дарга хурлыг олон талын оролцоотой зохион байгуулахын тулд малчдын бүлэг, нөхөрлөл, иргэний нийгмийн байгууллага, нутгийн иргэд зэрэг бүх талуудад зар хүргэв. Үүний дүнд хурал ирц сайтай болов.





Д.Болд:

- Манай Багийн нутагт “Эрдэс” гэж компани уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх хүсэлтэй байгаа юм байна. Тэд Ашигт малтмал, газрын тосны газарт (АМГТГ) хандаж хайгуулын тусгай зөвшөөрөл хүссэн өргөдөл гаргажээ.
- АМГТГ нь Эрдэс компаниас ирүүлсэн өргөдлийг хянаж үзээд бүртгэх шатны зохих шаардлага хангаж байгаа тул тусгай зөвшөөрөл хүссэн талаарх мэдээллийг манай аймгийн Засаг даргад 30 хоногт багтаан саналаа ирүүлэх тухай албан бичгийг хүргүүлжээ.
- Аймгийн Засаг дарга Төрмөнх манай сумын Засаг дарга Түмэнцэцэгт хандан орон нутгийн иргэд нь ямар байр суурьтай байгаа талаар санал авах тухай бичиг хүргүүлжээ.
- Энэ дагуу сумын Засаг дарга Түмэнцэцэг сумын иргэдийн төлөөлөгчдийн хурлын даргад, хүсэлт гаргасан талбайд байрлах багийн Засаг даргад иргэд ямар байр суурьтай байгаа талаар санал авах бичиг хүргүүлсэн байна.

- Сумын иргэдийн төлөөлөгчдийн хурлын дарга Сумын иргэдийн төлөөлөгчдийн хурлаар хэлэлцэн санал өгнө. Ийнхүү санал өгөхдөө багийн иргэдийн нийтийн хурлын шийдвэрийг харгалзан үзэх нь зүйтэй.
- Багийн Засаг дарга нь Багийн иргэдийн нийтийн хурлыг хуралдуулж иргэдийн саналыг авсаны үндсэн дээр хурлын тогтоол гаргана. Мөн иргэдээс санал авахдаа иргэний нийгмийн байгууллагын оролцоог хангаж, тэдний байр суурийг хамт тусган сумын Засаг даргад хандсан албан бичгийг хүргүүлнэ. Улмаар сумын Засаг дарга нь аймгийн Засаг даргад хандсан бичиг хүргүүлэх, Аймгийн засаг дарга нь АМГТГ-т хандсан бичгийг тус тус хүргүүлнэ.
- Хуулийн хүрээнд дээрх үйл ажиллагаа бүрэн явагдсан тохиодолд АМГТГ нь “Эрдэс” компанид хайгуулын тусгай зөвшөөрөл олгож холбогдох төлбөрийг төлүүлнэ.

Нэмэлт мэдээлэл:
Хэрэв орон нутаг хуулийн хугацаанд ямар нэгэн санал ирүүлэхгүй бол АМГТГ нь аж ахуйн нэгжид тусгай зөвшөөрлийг шууд олгодог хуулийн заалттайг талуудад анхааруулах,

Өргөдөл гаргаж буй талбай нь
- тусгай хэрэгцээний газар, ашигт малтмал хайх, ашиглахыг хориглосон газар, нөөцөд авсан талбайтай ямар нэгэн байдлаар давхцаагүй,
- хэлбэрийн хувьд дөрвөн өнцөгт хэлбэртэй байх бөгөөд түүний хил нь уртраг, өргөргийн дагуух чиглэлтэй давхацсан шулуун шугамаар хүрээлэгдсэн байна.
- Мөн нэг тусгай зөвшөөрлөөр олгох хайгуулын талбайн хэмжээ 25 гектараас багагүй, 150 мянган гектараас ихгүй байна.

1. “Эрдэс” компани АМГТГ-д хайгуулын тусгай зөвшөөрөл хүссэн өргөдөл гаргажээ.
2. АМГТГ нь Аймгийн Засаг даргад 30 хоногт багтаан саналаа ирүүлэхийг хүсчээ.
3. Аймгийн Засаг дарга тухайн сумын засаг даргад хандана.
4. Сумын Засаг дарга тухайн багийн Засаг даргад хандана.
5. Багийн Засаг дарга багийн нийтийн хурлыг хуралдуулж иргэдийн саналыг авч тогтоол гаргана.
6. Багийн хурлын шийдвэрийг сумын Засаг даргад хүргүүлнэ.
7. Сумын Засаг дарга сумын иргэдийн хуралд хүргүүлнэ.
8. Сумын иргэдийн хурал хуралдаж саналаа өгөх бөгөөд үүнийг аймгийн Засаг даргад хүргүүлнэ.
9. Аймгийн засаг дарга Сумын иргэдийн хурлын саналыг үндэслэн саналаа АМГТГ хүргүүлнэ.



Багийн иргэдийн нийтийн хуралд оролцсон дийлэнх иргэн зөвшөөрсөн талаарх тогтоолыг багийн Засаг дарга сумын иргэдийн хурлын даргад илгээв.

Сумын ИТХ-ын дарга Д.Түмэнцэцэг багийн засаг дарга Д.Болдын албан бичгийг хүлээн авч Сумын иргэдийн төлөөлөгчдийн хурлаар хэлэлцэн сумын ИТХ-н шийдвэрээ сумын Засаг дарга Энхээд гаргаж өгнө.

Сумын Засаг дарга А.Энхээ аймгийн Засаг даргадаа нутгийн иргэдийн шийдвэрийг уламжлахаар үзгээ авав.



Аймгийн Засаг дарга И.Төрмөнх сумын Засаг дарга А.Энхээгийн гарын үсэг бүхий албан бичигтэй танилцаж 30 хоногийн дотор АМГТГ-аас ирүүлсэн, нутгийн бүх шатны байгууллагын саналыг сонсох хүсэлтэд хариу өгөх үүрэгтэй.

Орон нутгийн бүх шатны байгууллага “Эрдэс” компани нутагт нь хайгуул хийхийг зөвшөөрсөн тул АМГТГ дараагийн шалгалтыг хийх ёстой.



Тус компани нь хайгуулын ажлаа хийж гүйцэтгэж байх үедээ дараах үүрэг хариуцлагыг үүрнэ.

- ☑ Хайгуулын ажлын төлөвлөгөө боловсруулж АМГТГ-аар хянуулж батлуулна. Мөн хайгуулын үеийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулж сумын Засаг даргаар батлуулна. Хайгуулын явцад ААН нь Хамтын ажиллагааны гэрээг сумын Засаг даргатай байгуулж ажиллана. Хайгуулын үед эвдэрсэн газрыг нөхөн сэргээж гүйцэтгэлийг орон нутагт актаар хүлээлгэж өгнө.

- ☑ Сумын Засаг дарга нь холбогдох мэргэжилтнүүдийг (иргэд болон ИНБ-ын төлөөлөл оролцох боломжтой) оролцуулсан ажлын хэсэг байгуулж хайгуулын үед эвдэрсэн газрын нөхөн сэргээлтийн гүйцэтгэлийг ажлын хэсгийн актаар хүлээж авна. Иргэдийн гаргасан санал гомдлыг тухай бүрт шийднэ.

- ☑ Сумын БО-ны хяналтын улсын байцаагч нь Байгаль хамгаалагчийн тавих ёстой хяналт, шалгалтыг давхар хийхийн зэрэгцээ хайгуулын ажлын үр дүнд эвдэрсэн газрыг нөхөн сэргээсэн байдлыг газар дээр нь шалгаж үнэлэлт, дүгнэлт өгч батлагдсан загвар /маягт-7/-ын дагуу акт үйлдэнэ. Энэ актыг ААН хайгуулын ажлыг тайлангаа батлуулахдаа АМГТГ-т хамт өгнө.

- ☑ Сумын байгаль хамгаалагч нь хайгуулын ажлын БОМТ-ний биелэлтийг газар дээр нь хянаж шалгах, хайгуулын ажлын явцад ашиглах усны хэмжээ төлбөр төлөлт, хог хаягдлын менежмент гэх мэт хуулиар олгогдсон эрх хэмжээнийхээ хүрээнд хяналт тавина.

- ☑ ААН нь Хамтын ажиллагааны гэрээг орон нутагтай байгуулна.

- ☑ Жил бүр Байгаль орчныг хамгаалах менежментийн төлөвлөгөө боловсруулж, биелүүлж, дүгнүүлж ажиллана.

ГУРВАН ЖИЛИЙН ДАРАА



“Эрдэс” компани хайгуулаа хийж дуусчээ. Тэд хайгуулын ажлын үр дүнд тулгуурлан ашиглалтын тусгай зөвшөөрөл авахаар төлөвлөж буй талбайдаа мэргэжлийн байгууллагаар археологи, палентологи, гидрогеологи, геотехникийн болон **Байгаль орчны төлөв байдлын судалгааг** тус тус гүйцэтгүүлжээ. “Эрдэс” компани нь байгаль орчны үнэлгээний тусгай эрх бүхий “Ногоон Ирээдүй” компанийг гэрээлэн Байгаль орчны төлөв байдлын судалгааг мэргэжлийн түвшинд гүйцэтгүүлжээ.“Ногоон Ирээдүй” нийтэд өгч болох мэдээллийг түгээж төсөл хэрэгжих нутгийн ард иргэдтэй ойр ажилласан байна.



А.Энхээ: “Эрдэс” компани ашиглалтын тусгай зөвшөөрөл авахад шаардлагатай баримт бичиг болох Байгаль орчны нөлөөллийн ерөнхий болон нарийвчилсан үнэлгээ хийлгэхэд орон нутгийн зүгээс татгалзах зүйлгүй болохыг илэрхийлэн БОАЖЯ-нд хандсан тодорхойлолт гаргуулах хүсэлт ирүүлсэн байна.

Бид Эрдэс компани нь хайгуулын ажлын үед байгаль орчныг хамгаалж ажилласан эсэх талаарх мэдээллийг сумын байгаль хамгаалагч, байгаль орчны хяналтын улсын байцаагч, иргэд, ИНБ-аас тодруулан АМГТГ-т тодорхойлолт өгнө. Үүнд:

- Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлт
- Хамтын ажиллагааны гэрээний биелэлт
- Эвдэрсэн газрыг нөхөн сэргээлтийн ажлын дүгнэлтийг ямар байсан талаар хэлэлцэж энэхүү тодорхойлолтыг гаргана.



> Энэ тодорхойлолт нь Байгаль орчны нөлөөллийн ерөнхий болон нарийвчилсан үнэлгээ хийлгэхэд орон нутгийн зүгээс татгалзах зүйлгүй болохыг илэрхийлэн БОАЖЯ-нд хандсан байна.



А.Энхээ: Эрдэс компани нь Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийлгэх болвол мэргэжлийн баг энд ирж судалгаа, шинжилгээ хийнэ. Тэд төсөл хэрэгжүүлснээр байгаль орчин, хүний эрүүл мэндэд үзүүлэх нөлөөллийг тооцон, нутгийн иргэдэд танилцуулах үүрэгтэй юм.

Д.Түмэнцэцэг: Бидний саналыг заавал сонсож, тайландаа хавсаргах ёстой тул иргэд бид тэр тайлангийн хуралд нь заавал сууж, мэдээлэл сонсон, байр суурыа илэрхийлэх хэрэгтэй.



Б.Ирээдүй: Тэгвэл иргэд бидний оролцоог хуулиар хангасан юм байна.



“Эрдэс” компани ашиглалтын тусгай зөвшөөрөл авахын тулд:

- Мэргэжлийн байгууллагаар урьдчилсан техник эдийн засгийн үндэслэл боловсруулж ордын нөөцийг тогтоож АМГТГ-ын Эрдэс баялагийн мэргэжлийн зөвлөлөөр батлуулна.
- БОАЖЯ–нд Байгаль орчны төлөв байдлын судалгааны тайлан болон орон нутгаас авсан тодорхойлолтыг Байгаль орчны нөлөөллийн ерөнхий болон нарийвчилсан үнэлгээ гаргуулахаар өгнө.

“Эрдэс” компанийн захиалгын дагуу БОНБҮ-ний тусгай эрх бүхий “Ногоон Ирээдүй” компанийн мэргэжлийн баг, экспертүүд төслийн талбайд судалгаа, шинжилгээ гүйцэтгэж шаардлагатай газруудын сорьц дээжийг шинжлүүлэн нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланг боловсруулна. Уг тайланд байгаль орчин болон хүний эрүүл мэндэд тус төслийн зүгээс үзүүлэх нөлөөллийг тооцон орон нутгийн иргэдэд танилцуулж, тэдний саналыг тайланд тусгана. Эцэслэн боловсруулсан тайланг БОАЖЯ-аар батлуулахаас өмнө нутгийн иргэдэд дахин танилцуулах үүрэгтэй.



БОАЖЯ нь “Ногоон Ирээдүй” мэргэжлийн байгууллагын боловсруулсан БОННҮ-ний тайлан болон эхний жилийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд орон нутгийн иргэдийн санал туссан байдлыг хянаж үзэхийн зэрэгцээ холбогдох шаардлага, шалгуур хангаж байгааг үнэлэн мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцэн батлах эсэхийг шийднэ.



АМГТГ нь ашиглалтын тусгай зөвшөөрөл хүссэн өргөдлийг хүлээж авсны дараа өргөдөл болон хавсралт бичиг баримтуудыг бүртгэх, мөн тэдгээр бичиг баримтууд хуулинд заагдсан шаардлагыг хангаж байгаа эсэхийг шалгаж, тухайн талбайг уурхайн зориулалтаар ашиглах боломжтой эсэхийг нягтална. Үүнд:

Өргөдлийг бүртгэснээс хойш ажлын 20 өдөрт багтаан зохих шийдвэр гаргаж өргөдөл гаргагчид мэдэгдэнэ. Хэрэв зөвшөөрөл олгохоос татгалзсан бол шалтгаан, хуулийн үндэслэлийг дурдсан хариуг өргөдөл гаргасан этгээдэд бичгээр мэдэгдэнэ.

Тусгай зөвшөөрөл олгох тухай шийдвэрийг хүлээн авсан этгээд мэдэгдэл авсан өдрөөс хойш 10 өдрийн дотор тусгай зөвшөөрлийн эхний жилийн төлбөрийг төлнө.


Өргөдөл гаргасан этгээд тусгай зөвшөөрлийн эхний жилийн төлбөрийг хуулийн дагуу хийснээс хойш ажлын 3 өдөрт багтаан ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрлийг 30 жилийн хугацаагаар олгож, уурхайн талбайн тусгай зөвшөөрлийг зураг зүйн бүртгэлд бүртгэнэ.

Ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл олгосноос хойш 7 хоногийн дотор багтааж байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааныбайгууллага, тухайн зөвшөөрлөөр олгогдсон талбай орших аймаг, сум, дүүргийн Засаг дарга, мэргэжлийн хяналтын газарт энэ тухай тус тус мэдэгдэж, өдөр тутмын сонинд нийтэлнэ.

“Эрдэс” компани нь

- Хамтын ажиллагааны гэрээг аймаг/сумын Засаг даргатай хийнэ.
- Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний эхний жилийн нийт зардлын 50 хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн дүнг сумын тусгай дансанд байршуулна.
- Дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлнэ.
- Жил бүрийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлж биелэлтийг хангах үүрэгтэй.
- Уурхай хаахаас 3 жилийн өмнө Уурхайн хаалтын нарийвчилсан төлөвлөгөөг Байгаль орчны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагаар батлуулан хэрэгжүүлнэ.
- Байгаль орчны аудитыг 2 жил тутам хийнэ.

Аймгийн Засаг дарга нь ажлын хэсэг томилж тухайн төслийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ын дагуу үнэлнэ. Түүнчлэн “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ын дагуу ИНБ болон иргэдийн оролцоог хангана. Тодруулбал: Иргэд, байгаль хамгаалах ИНБ, тухайн сумын байгаль хамгаалагч болон байгаль орчны хяналтын улсын байцаагч, газрын даамал, сав газрын төлөөлөл, аймгийн БОАЖГ-ын төлөөлөл, аймгийн мэргэжлийн хяналтын газрын төлөөлөл гэх мэт бүрэлдэхүүнтэй байна. БОМТ-ний биелэлт хангалттай дүн (80 хувиас дээш) үзүүлсэн тохиолдолд ААН барьцаа хөрөнгөө буцааж авна.





Уул уурхайн шинэ төсөл эхлэх үед орон нутгийн иргэд ямар оролцоо, үүрэгтэй талаар та бүхэнд танилцууллаа.

Танай баг, суманд одоо ямар төсөл хэрэгжиж байна вэ? Тэдгээр төслийг эхлүүлэхээс өмнө таны оршин суудаг баг, сумын удирдлагууд дээр бичсэнчлэн тантай хамтран ажиллаж, та бүхний саналыг сонссон уу?

Та хамгийн сүүлд хэзээ багийн нийтийн хуралдаа суусан бэ?

Иргэд уул уурхайн шинэ төсөл эхлэхээс өмнө буюу хайгуулын ажлыг эхлүүлэхийн өмнө саналаа өгөх ЭРХТЭЙ. Энэ эрхээ хэрэгжүүлэх арга зам нь багийн нийтийн хуралдаа суух.

Гэвч олон иргэн энэ эрхээ хэзээ, хэрхэн эдлэхээ мэдэхгүйгээс эдэлж чадахгүй байна.

ТЭМДЭГЛЭЛ

УУЛ УУРХАЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ОРОН НУТГИЙН ЗАХИРГАА БА ИРГЭДИЙН ОРОЛЦОО

Хайгуулийн тусгай зөвшөөрөл хүсэх өргөдөл гаргана.

→ Ашигт малтмал, газрын тосны газар шүүлт хийж талбайг олгох боломжтой гэж үзсэн тохиолдолд тухайн талбай байрлах Аймгийн Засаг даргаас санал авахаар холбогдох баримтын хүргүүлнэ.

Сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын саналыг үндэслэн аймгийн иргэдийн хурлын тэргүүлэгчид шийдвэрээ гаргана.

→ Сумын Иргэдийн төлөөлөгчдийн санал болон аймгийн Иргэдийн хурлын тэргүүлэгчдийн саналыг үндэслэн аймгийн Засаг дарга Ашигт малтмал, газрын тосны газарт 30 хоногт багтаан хүргүүлнэ.

Аж ахуйн нэгж нь хайгуулын тусгай зөвшөөрөл авсны дараа хайгуулийн ажил эхлэхээс өмнө хайгуулийн ажлын Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө боловсруулан сумын Засаг даргаар батлуулна.

→ Аж ахуйн нэгж нь орон нутагтай Хамтын ажиллагааны гэрээ байгуулж ажиллана. Хамтын ажиллагааны хорооны нийт 9 гишүүнээс 3 нь иргэдийн төлөөлөл байна.

Орон нутгаас хайгуулын ажил гүйцэтгэх хугацаандаа байгаль орчны хууль, тогтоомжийг биелүүлж ажилласан тухай тодорхойлолт болон Хайгуулын ажлын нөхөн сэргээлтийн акт үйлдсэн баримтуудыг Ашигт малтмал, газрын тосны газарт хүргүүлнэ.

→ Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг мэргэжлийн тусгай зөвшөөрөл бүхий байгууллагаар гүйцэтгүүлнэ.

Ашигт малтмал, газрын тосны газарт шаардлагатай материалыг хүргүүлэн ашиглалтын тусгай зөвшөөрөл авна.

→ Хамтын ажиллагааны гэрээг орон нутгийн захиргаатай байгуулна. Хамтын ажиллагааны хорооны нийт 9 гишүүнээс 3 нь иргэдийн төлөөлөл байна.

Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг 5 жил тутам тодотгох ба төсөлтэй холбоотой өөрчлөлт гарсан тохиолдолд мөн нарийвчилсан үнэлгээг тодотгоно. Дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөөг төслийн цар хүрээ хэрэгжих хугацаанд хамруулан боловсруулж хэрэгжүүлнэ.

→ Одоогийн эрх зүйн зохицуулалтаар уурхай хаахаас 3 жилийн өмнө уурхайн хаалтын төлөвлөгөөг боловсруулан төрийн захиргааны төв байгууллагаар батлуулж хэрэгжүүлнэ.

Ашигт малтмал, газрын тосны газраас ирсэн баримтыг аймгийн Засаг дарга Сумын Иргэдийн төлөөлөгчдийн хуралд мөн санал авахаар хүргүүлнэ.

Зөвхөн хуульд заасан үндэслэлээр тухайн орон нутгийн захиргаа татгалзсан тохиолдолд Ашигт малтмал, газрын тосны газар тусгай зөвшөөрөл олгохоос татгалзаж болно. Бусад тохиолдолд тусгай зөвшөөрөл олгоно.

Ашиглалтын тусгай зөвшөөрөл хүссэн өргөдөл Ашигт малтмал, газрын тосны газарт гаргана.

Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг гүйцэтгэхэд тухайн төсөл хэрэгжих газар нутгийн иргэдээс холбогдох саналыг авна.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө, Хамтын ажиллагааны гэрээг жил бүр болорсруулан хэрэгжүүлнэ. Байгалийн нөөц, баялаг ашигладаг аж ахуйн нэгж 2 жил тутамд байгаль орчны аудитыг мэргэжлийн тусгай эрхтэй байгууллагаар хийлгэнэ.

Орон нутгийн захиргааны оролцоо

Орон нутгийн иргэдийн оролцоо

2018

1 дүгээр сар

Да	Мя	Лх	Пү	Ба	Бя	Ня
1	2	3	4	5	6	7
8	9	10	11	12	13	14
15	16	17	18	19	20	21
22	23	24	25	26	27	28
29	30	31				

2 дугаар сар

Да	Мя	Лх	Пү	Ба	Бя	Ня
			1	2	3	4
5	6	7	8	9	10	11
12	13	14	15	16	17	18
19	20	21	22	23	24	25
26	27	28				

3 дугаар сар

Да	Мя	Лх	Пү	Ба	Бя	Ня
			1	2	3	4
5	6	7	8	9	10	11
12	13	14	15	16	17	18
19	20	21	22	23	24	25
26	27	28	29	30	31	

4 дүгээр сар

Да	Мя	Лх	Пү	Ба	Бя	Ня
30						1
2	3	4	5	6	7	8
9	10	11	12	13	14	15
16	17	18	19	20	21	22
23	24	25	26	27	28	29

5 дугаар сар

Да	Мя	Лх	Пү	Ба	Бя	Ня
	1	2	3	4	5	6
7	8	9	10	11	12	13
14	15	16	17	18	19	20
21	22	23	24	25	26	27
28	29	30	31			

6 дугаар сар

Да	Мя	Лх	Пү	Ба	Бя	Ня
				1	2	3
4	5	6	7	8	9	10
11	12	13	14	15	16	17
18	19	20	21	22	23	24
25	26	27	28	29	30	

7 дугаар сар

Да	Мя	Лх	Пү	Ба	Бя	Ня
30	31					1
2	3	4	5	6	7	8
9	10	11	12	13	14	15
16	17	18	19	20	21	22
23	24	25	26	27	28	29

8 дугаар сар

Да	Мя	Лх	Пү	Ба	Бя	Ня
		1	2	3	4	5
6	7	8	9	10	11	12
13	14	15	16	17	18	19
20	21	22	23	24	25	26
27	28	29	30	31		

9 дүгээр сар

Да	Мя	Лх	Пү	Ба	Бя	Ня
					1	2
3	4	5	6	7	8	9
10	11	12	13	14	15	16
17	18	19	20	21	22	23
24	25	26	27	28	29	30

10 дугаар сар

Да	Мя	Лх	Пү	Ба	Бя	Ня
1	2	3	4	5	6	7
8	9	10	11	12	13	14
15	16	17	18	19	20	21
22	23	24	25	26	27	28
29	30	31				

11 дүгээр сар

Да	Мя	Лх	Пү	Ба	Бя	Ня
			1	2	3	4
5	6	7	8	9	10	11
12	13	14	15	16	17	18
19	20	21	22	23	24	25
26	27	28	29	30		

12 дугаар сар

Да	Мя	Лх	Пү	Ба	Бя	Ня
31					1	2
3	4	5	6	7	8	9
10	11	12	13	14	15	16
17	18	19	20	21	22	23
24	25	26	27	28	29	30

2019

1 дүгээр сар

Да	Мя	Лх	Пү	Ба	Бя	Ня
	1	2	3	4	5	6
7	8	9	10	11	12	13
14	15	16	17	18	19	20
21	22	23	24	25	26	27
28	29	30	31			

2 дугаар сар

Да	Мя	Лх	Пү	Ба	Бя	Ня
				1	2	3
4	5	6	7	8	9	10
11	12	13	14	15	16	17
18	19	20	21	22	23	24
25	26	27	28			

3 дугаар сар

Да	Мя	Лх	Пү	Ба	Бя	Ня
				1	2	3
4	5	6	7	8	9	10
11	12	13	14	15	16	17
18	19	20	21	22	23	24
25	26	27	28	29	30	31

4 дүгээр сар

Да	Мя	Лх	Пү	Ба	Бя	Ня
1	2	3	4	5	6	7
8	9	10	11	12	13	14
15	16	17	18	19	20	21
22	23	24	25	26	27	28
29	30					

5 дугаар сар

Да	Мя	Лх	Пү	Ба	Бя	Ня
		1	2	3	4	5
6	7	8	9	10	11	12
13	14	15	16	17	18	19
20	21	22	23	24	25	26
27	28	29	30	31		

6 дугаар сар

Да	Мя	Лх	Пү	Ба	Бя	Ня
					1	2
3	4	5	6	7	8	9
10	11	12	13	14	15	16
17	18	19	20	21	22	23
24	25	26	27	28	29	30

7 дугаар сар

Да	Мя	Лх	Пү	Ба	Бя	Ня
1	2	3	4	5	6	7
8	9	10	11	12	13	14
15	16	17	18	19	20	21
22	23	24	25	26	27	28
29	30	31				

8 дугаар сар

Да	Мя	Лх	Пү	Ба	Бя	Ня
			1	2	3	4
5	6	7	8	9	10	11
12	13	14	15	16	17	18
19	20	21	22	23	24	25
26	27	28	29	30	31	

9 дүгээр сар

Да	Мя	Лх	Пү	Ба	Бя	Ня
30						1
2	3	4	5	6	7	8
9	10	11	12	13	14	15
16	17	18	19	20	21	22
23	24	25	26	27	28	29

10 дугаар сар

Да	Мя	Лх	Пү	Ба	Бя	Ня
	1	2	3	4	5	6
7	8	9	10	11	12	13
14	15	16	17	18	19	20
21	22	23	24	25	26	27
28	29	30	31			

11 дүгээр сар

Да	Мя	Лх	Пү	Ба	Бя	Ня
				1	2	3
4	5	6	7	8	9	10
11	12	13	14	15	16	17
18	19	20	21	22	23	24
25	26	27	28	29	30	

12 дугаар сар

Да	Мя	Лх	Пү	Ба	Бя	Ня
30	31					1
2	3	4	5	6	7	8
9	10	11	12	13	14	15
16	17	18	19	20	21	22
23	24	25	26	27	28	29

2020

1 дүгээр сар

Да	Мя	Лх	Пү	Ба	Бя	Ня
		1	2	3	4	5
6	7	8	9	10	11	12
13	14	15	16	17	18	19
20	21	22	23	24	25	26
27	28	29	30	31		

2 дугаар сар

Да	Мя	Лх	Пү	Ба	Бя	Ня
					1	2
3	4	5	6	7	8	9
10	11	12	13	14	15	16
17	18	19	20	21	22	23
24	25	26	27	28	29	

3 дугаар сар

Да	Мя	Лх	Пү	Ба	Бя	Ня
30	31					1
2	3	4	5	6	7	8
9	10	11	12	13	14	15
16	17	18	19	20	21	22
23	24	25	26	27	28	29

4 дүгээр сар

Да	Мя	Лх	Пү	Ба	Бя	Ня
		1	2	3	4	5
6	7	8	9	10	11	12
13	14	15	16	17	18	19
20	21	22	23	24	25	26
27	28	29	30			

5 дугаар сар

Да	Мя	Лх	Пү	Ба	Бя	Ня
				1	2	3
4	5	6	7	8	9	10
11	12	13	14	15	16	17
18	19	20	21	22	23	24
25	26	27	28	29	30	31

6 дугаар сар

Да	Мя	Лх	Пү	Ба	Бя	Ня
1	2	3	4	5	6	7
8	9	10	11	12	13	14
15	16	17	18	19	20	21
22	23	24	25	26	27	28
29	30					

7 дугаар сар

Да	Мя	Лх	Пү	Ба	Бя	Ня
		1	2	3	4	5
6	7	8	9	10	11	12
13	14	15	16	17	18	19
20	21	22	23	24	25	26
27	28	29	30	31		

8 дугаар сар

Да	Мя	Лх	Пү	Ба	Бя	Ня
31					1	2
3	4	5	6	7	8	9
10	11	12	13	14	15	16
17	18	19	20	21	22	23
24	25	26	27	28	29	30

9 дүгээр сар

Да	Мя	Лх	Пү	Ба	Бя	Ня
	1	2	3	4	5	6
7	8	9	10	11	12	13
14	15	16	17	18	19	20
21	22	23	24	25	26	27
28	29	30				

10 дугаар сар

Да	Мя	Лх	Пү	Ба	Бя	Ня
			1	2	3	4
5	6	7	8	9	10	11
12	13	14	15	16	17	18
19	20	21	22	23	24	25
26	27	28	29	30	31	

11 дүгээр сар

Да	Мя	Лх	Пү	Ба	Бя	Ня
30						1
2	3	4	5	6	7	8
9	10	11	12	13	14	15
16	17	18	19	20	21	22
23	24	25	26	27	28	29

12 дугаар сар

Да	Мя	Лх	Пү	Ба	Бя	Ня
	1	2	3	4	5	6
7	8	9	10	11	12	13
14	15	16	17	18	19	20
21	22	23	24	25	26	27
28	29	30	31			

Худалдаалахыг хориглоно

ДЭЛХИЙН БАЙГАЛЬ ХАМГААЛАХ САН (WWF)-ГИЙН МОНГОЛ ДАХЬ ХӨТӨЛБӨРИЙН ГАЗАР

1992 он

Монгол Улсад 1992 онд байгуулагдсан.

2 газар нутаг

Алтай-Соёны бүс нутаг болон Амар мөрний сав газарт ажилладаг.

10.6 сая га

Нийт 10.6 сая га газрыг тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээнд хамруулсан нь нийт хамгаалалттай газар нутгийн 39 хувийг эзэлж байна.



5 сав газар

Усны нөөцийн нэгдсэн менежментийг Хар нуур-Ховд, Онон, Хяргас нуур-Завхан, Хэрлэн болон Хүйсийн говь-Цэцэг нуурын сав газруудад санаачлан хэрэгжүүлж байна.

5

Цэнгэг ус, ойн экосистем, цоохор ирвэс, Монгол бөхөн зэрэг нэн ховор амьтан, тал хээрийн нуруутны нүүдэл гэсэн экологийн процессыг төлөөлөл болгон сонгон авч байгаль хамгааллын үйл ажиллагаагаа явуулж байна.

2013 он

Байгаль орчин, ногоон хөгжлийн яамтай байгуулсан гэрээний дагуу 2013 оноос эхлэн Хар ямаатын байгалийн нөөц газрын менежментийг хариуцан ажиллаж байна.

+140

Нийт 140 гаруй байгаль хамгаалах иргэдийн нөхөрлөл байгуулан, дэмжин ирсэн.

+ 600

Бид байгаль хамгаалах 24 клубын 600 гаруй сурагчидтай хамтарч ажилладаг.

ISBN 999781521-1

Бидний эрхэм зорилго:
Монгол орон зэрлэг ан амьтан, ургамлын өлгий нутаг байж, хүн ард нь байгальтайгаа шүтэлцэн үеийн үед сэтгэл хангалуун амьдрах ирээдүйг бүтээхэд оршино.

Холбоо барих хаяг:
Утас: +(976)-11-311658
Факс: +(976)-11-310237
И-мэйл: info@wwf.mn